

“Тэр өдрүүдэд Би шивэгчингүүд дээр ч Өөрийн Сүнсийг цутгана”

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхий ерөнхийлөгч

Жюли Б.Бек

Бид Ариун Сүнсийг хүлээн авахад тэнцэхээр байж, түүнийг хэрхэн дагавал зохихыг мэдсэнээр ажил амьдрал маань өөдрөг байх болно гэдгийг мэддэг.

Өнгөрсөн жил би олон оронд очиж Хожмын Үеийн Гэгээнтэн мянга мянган эмэгтэйчүүдтэй уулзан танилцлаа. Эдгээр эгч нарт тулгарч буй бэрхшээлийн жагсаалт урт бөгөөд тэдгээр нь сэтгэл эмзэглүүлэм мөн санаа зовоомоор зүйлүүд байлаа. Гэр бүлд тохиолдож буй гай зовлон, эдийн засгийн хямрал, байгалийн гамшиг, аваар осол, өвчин эмгэгийг тоочоод баршгүй юм. Санаа зовоох асуудлууд хэтэрхий ихсэхэд амар амгалан, аз жаргал улам бүр хумигдаж байна. Мэдээллийн хэрэгслүүдийн өнгө засч гоёсон, хуурмаг захиасыг эс тооцвол, жинхэнэ баян хүн гэж алга, жинхэнэ сайн сайхан юм гэж алга, мөнх бус амьдралд тохиолдох зүйлсээс зайлсхийж чадах ухаантан ч алга.

Эгч нар нухацтай бөгөөд бодууштай асуултууд асуудаг. Тэд ирээдүйн талаар сэтгэл зовниж, биелээгүй хүслийнхээ төлөө сэтгэлийнхээ гүнд харамсал тээж явдаг. Тууштай биш зарим нь өөрсдийнхөө үнэ цэнийг доогуур тавьдаг ч тэд мөн зөвийг хийх энгүй их хүсэл тэмүүлэлтэй хүмүүс байдаг.

Бурханы охидын үнэ цэнийн талаар би бат бөх гэрчлэлтэй болсон хүн. Олон зүйл тэднээс хамааралтай юм. Би эгч нартай уулзаж учран, ярьж хөөрч явахдаа, итгэл,хувийн зохистой байдлаа нэмэгдүүлэх хэрэгцээ урьд өмнө нь хэзээ ч ийм их байгаагүйг анзаарч мэдэрсэн

билээ. Бат бөх төлөвшсөн гэр бүл хэзээ ч одоо шиг ийм их хэрэгтэй байсангүй. Тусламж хэрэгтэй хүмүүсийн төлөө хийх зүйл урьд өмнө хэзээ ч ийм их байгаагүй юм. Хүн хэрхэн итгэлээ нэмэгдүүлж, гэр бүлээ бэхжүүлж, бусдыг хайрлан халамжилж чадах вэ?¹ Бидний өнөө үед эмэгтэй хүн хэрхэн асуултууддаа хариу олж, урьд өмнө хэзээ ч байгаагүй ийм их эсэргүүцэл, хүндрэл бэрхшээлийн эсрэг хэрхэн бат бөх, тууштай зогсож чадах вэ?

Хувийн илчлэлт

Бүх хүмүүст анхаарал халамж тавих, зүрх сэтгэлийнхээ хүслэн болсон бүх зөв зүйлсийг хийх хангалттай цаг зав, хүч чадал, боломж нөхцөл өөрт нь байдаггүйг эмэгтэйчүүд мэддэг. Ихэнх эмэгтэйчүүдийн амьдрал амар амгалан биш байна. Тэд өдөр бүр үй түмэн чухал юмсыг хийх хэрэгтэй болдог. Сайн эмэгтэй хүн чухал үүрэг хариуцлагаасаа хөндийрч, бие дааж, амар хялбар амьдрах эрхтэй гэхчлэн худал хуурмаг маш олон мэдээллийн эсрэг байнга тэмцэх ёстой болж байна. Гэвч тэр хувийн илчлэлт хүлээж авснаар зөв дарааллыг буй болгож, амьдралаа итгэлтэйгээр жолоодож чадна.

Хувийн илчлэлт хүлээн авахаар зохистой байж, улмаар илчлэлт хүлээн авч, хэрэгжүүлэх чадвар бол энэ амьдралд олж авах нэн чухал чадвар юм. Их Эзэний Сүнснийг хүлээн авахад тэнцэхээр байхын тулд Ариун Сүнснийг эгээрэн хүсэхийн зэрэгцээ зохистой байх хэрэгтэй юм. Зарлигуудыг дагаж, нүглээ наманчлан, баптисм хийлгэхдээ хийсэн гэрээгээ шинэчлэх нь Их Эзэний Сүнс үргэлж бидэнтэй хамт байх адислалыг боломжтой болгодог билээ.² Ариун Сүмд гэрээнүүд хийж, сахих нь эмэгтэй хүний амьдралд сүнсний хүч чадлыг нэмдэг. Олон хэцүү асуултын хариултыг судар уншсанаар олж болно. Учир нь судрууд

илчлэлт хүлээн авахад тусалдаг.³ Судруудаас олж авсан гүнзгий ойлголтууд цаг хугацааны явцад өсөн нэмэгддэг билээ. Тиймээс өдөр бүр судар уншихад тодорхой цаг гаргаж байх хэрэгтэй. Бас өдөр бүр залбирах нь Их Эзэний Сүнстэй байхад зайлшгүй хэрэгтэй юм.⁴ Залбирч, судраас судалснаар тусламжийг шаргуу эрж хайдаг хүн асуултуудыг бичиж, төрсөн сэтгэгдэл, санаа бодлоо тэмдэглэхээр цаас, харандаа бэлтгэж хажуудаа тавих нь олонтоо байдаг.

Биднийг зөв зохистой байх үед илчлэлт цаг, хором бүрд ирэх болно. Эмэгтэйчүүд Христийн адилаар халамжлах аваас тусламж хэрэгтэй яг тэр мөчид хүч чадал, амар амгалан нь тэдэнд ирэх болно. Жишээ нь, эхчүүд ядарсан үедээ ч, хүүхдийн дуу шуугиан анхаарлыг нь сарниулсан үед ч Сүнсний тусламжийг мэдэрч чаддаг. Харин үр хүүхдэдээ уурлаж бухимдвал Сүнснээс холдож болно. Зөв газарт байх нь сүнслэг удирдамж хүлээн авах боломжийг бидэнд олгодог. Анхаарал сарниулах зүйлсээс зайлсхийхэд зориудын хүч чармайлт шаардлагатай байдаг. Илчлэлтийн Сүнстэй байх нь бэрхшээл сорилтыг итгэлээр даван туулахад тусална. Хувиараа илчлэлт хүлээж авах нь итгэл, хувийн шударга зан чанараа өсгөн нэмэгдүүлэх, гэр бүлээ бэхжүүлэх болон бидний тусламж хэрэгтэй байгаа хүмүүсийг эрж олохын тулд өдөр бүр юу хийх ёстойгоо ойлгох боломжийг бидэнд олгодог. Хувийн илчлэлт бол хүч чадлыг байнга шинэчлэх эх сурвалж учраас ороо бусгай, үймээн самуунтай үед ч бид найдвартай тусламж хүлээн авах боломжтой юм.

Биднийг “шударгаар үйлдэхэд, даруухнаар алхахад мөн зөв шударгаар шүүхэд”⁵ хөтөлдөг Сүнсэнд итгэлтэй байх ёстой гэдэг. Мөн энэ Сүнс нь оюуныг гэгээрүүлж, сүнсийг баяраар дүүргэж, бидний хийх ёстой бүхнийг мэдэхэд тусална гэж заасан байдаг.⁶

Бид хувийн илчлэлтийг хүсч, хүлээн авахад бэлтгэн, илчлэлт ирэх болно гэдэгт гуйвшгүй итгэлтэй байвал амлагдсан хувийн илчлэлт ирэх болно.

Нийгмийн Халамжийн Бүлэг зааж, Сүнсээр өдөөж, бэхжүүлдэг

Түүнээс гадна Их Эзэн мэргэн ухаанаараа энэхүү эцсийн өдрүүдэд Өөрийн охидод туслахын тулд Нийгмийн Халамжийн Бүлгийг өгсөн юм. Нийгмийн Халамжийн Бүлэг сүнсээр өдөөгдсөн арга замаар үйл ажиллагаагаа явуулсан үед, энэ нь үймээн самуунтай, айдас түгшүүрээр дүүрэн дэлхийд эмэгтэйчүүдийг өргөн, дэлхийгээс холдуулж, мөнх амьдралын адислалд бэлтгэх зам дээр гаргадаг. Энэ бүлэг нь итгэл, хувийн зөв зохистой байдлаа хөгжүүлж, гэр бүлээ бэхжүүлэн, тусламж хэрэгтэй хүмүүсийг эрж олоход туслах чухал үүрэгтэй юм. Нийгмийн Халамжийн Бүлгээр дамжуулан эгч нар асуултууддаа хариу олж, сүнсний хүчээр адислагддаг. Нийгмийн Халамжийн Бүлэг Бурханы охидын жинхэнэ, мөнхийн мөн чанарыг нотлон харуулдаг юм. Энэ бол эмэгтэйчүүдэд бат бөх, гуйвшгүй тууштай байхыг зааж, урам дэм хайрладаг, ариун итгэмжлэл, удирдлагын гэрэл өгдөг, анхаарал, халамж тавьдаг байгууллага юм. Нийгмийн Халамжийн Бүлгийн уриа нь “Энэрэл хэзээ ч дуусдаггүй”⁷ гэсэн үгс бөгөөд энэ уриа бүх сайн эмэгтэйчүүдийн зүрх сэтгэлд шингэсэн байдаг.

Залуу охин Нийгмийн Халамжийн Бүлэгт дэвшсэнээр, аль эсвэл нэгэн эмэгтэй Сүмд баптисм хийлгэсэн үед өөрийгөө мөнх амьдралд бэлтгэх үйл явцыг эхлүүлснээр, эгч дүүсэг харилцааны нэг хэсэг болдог билээ. Эмэгтэй хүн Нийгмийн Халамжийн Бүлэгт

дэвшин шилжих нь Их Эзэний хаант улсыг байгуулахад хаана ч байсан ялгаагүй, тодорхой хэмжээгээр хувь нэмэр оруулах итгэл хүлээдгийг харуулдаг юм. Тэрээр хувь хүний хувьд үргэлж өсч хөгжих нь бүхний анхаарлыг татаж, сайшаал магтаал хүлээх зүйл биш, харин ердийн л хийх зүйл нь юм. Нийгмийн Халамжийн Бүлгийн хоёр дахь ерөнхий ерөнхийлөгч Элайза Р.Снөү эгч нарт хандан ийн хэлжээ: “Бид энэ үеийн дэлхийн үнэлэмжээр биш, харин Бурхан болон Ариун Хүмүүсийн хамтрагч байхад тохирох жинхэнэ нигүүлсэнгүй сэтгэлт эмэгтэйчүүд байхыг хүсдэг. Бид зохион байгуулалттай хүчний хувьд зөвхөн сайн үйлсийг бүтээхэд төдийгүй өөрсдийгөө ариусган төгөлдөржүүлэхэд бие биедээ тусалдаг. Энэхүү агуу ажлыг гүйцэтгэхэд тусалсан олон ч бай цөөн ч бай гагцхүү тэр хүмүүс л Бурханы хаант улсад хүндтэй суудлыг эзлэх болно. . . Эмэгтэйчүүд илж таалуулж энхрийлүүлсэн, эсвэл юм бүхнийг зааж залруулж өгдөг нялх хүүхэд шиг биш, харин төлөвшиж буурь суусан эмэгтэйчүүд байх ёстой. Бид талархал хүлээх дуртай. Гэтэл бидэнд илэрхийлэх ёстой гэж хүсэн хүлээсэн талархлаа хүлээн авахгүй бол яах вэ? Их Эзэн бидэнд өндөр үүрэг хүлээлгэснийг бид мэднэ. Бидний зүрх сэтгэлд Их Эзэний суулгасан зөв хүсэл бүхэн биелэгдэх бөгөөд өөрсдийнхөө төлөө, бие биенийхээ төлөө хийж чадах хамгийн агуу зүйл нь эдгээр үүргээ биелүүлэхийн тулд сайн сайхан бүхнээр өөрсдийгөө хөгжүүлж, ариусгах явдал юм.”⁸

Амжилтын хэмжүүр

Сайн эмэгтэйчүүд ажил үйлс, амьдрал ахуйдаа амжилттай байгаа эсэхээ мэдэхийг хүсдэг Амжилтын хэмжүүр ихээхэн гуйвуулагдсан дэлхийд бид зөв эх сурвалжаас талархал болон баталгааг хайх нь чухал юм. Миний *сайн мэдээг номло* удирдамж дахь жагсаалтыг өөр үгээр илэрхийлвэл, Есүс Христийн зан чанаруудыг өөрсөддөө хөгжүүлж, Түүний бүрэн сайн мэдээг дагахыг хичээсэн үед бид амжилттай байна гэсэн үг. Бид өөрсдийгөө хөгжүүлэхийг эрэлхийлж, чадах бүхнээ хийсэн үед амжилтанд хүрч чадна. Бид итгэл, хувийн зөв зохистой байдлаа хөгжүүлж, гэр бүлээ бэхжүүлэн, тусламж хэрэгтэй хүмүүсийг эрж олон, гараа тэдэнд сунгасан үед амжилтанд хүрч чадна. Бид Сүнсийг сонсохоор зохистой байж, үүнийг хүлээн авч, хэрхэн дагахыг мэдэж амьдарвал бид амжилттай байгаагаа мэднэ. “Бид чадах бүхнээ хийсэн үед, сэтгэл гонсойлгох явдалтай тулгарсан ч, өөрсөддөө сэтгэл дундуур биш байх болно. Их Эзэн Сүнсээр дамжуулан бидэнтэй ажиллаж байгааг бид мэдрэхдээ баяртай байдаг.”⁹ Амжилтаа даруухнаар үнэлдэг хүмүүст амар амгалан, баяр баясгалан, итгэл найдвар ирдэг.

Иоелын номонд Бурханы охид, хөвгүүд эцсийн өдрүүдэд эш үзүүлж, Их Эзэн Өөрийн зарц, шивэгчингүүд дээр ч Өөрийн Сүнсийг цутгах болно¹⁰ гэсэн нэгэн илчлэлт байдаг.

Ерөнхийлөгч Кимбалл энэ бошиглол дээр тулгуурлан эгч нарт хандан ийн хэлжээ:

“Дэлхийн олон сайн эмэгтэйчүүд (тэдэнд сүнслэг байдлын гүн гүнзгий мэдрэмж заяагдмал байх нь олонтоо тохиолддог) Сүмд үй олноороо нэгдэх учраас эцсийн өдрүүдэд Сүмд агуу өсөлт тохиох болно. Сүмийн эмэгтэйчүүд зөв шударга зан чанар, амьдралд өөрсдийгөө илэрхийлэх саруул ухаанаар дэлхийн эмэгтэйчүүдээс олон талаараа ялгаатай юм. . .

“Тиймээс Сүмийн эмэгтэйчүүдийн үлгэр жишээ эцсийн өдрүүдэд Сүмийн тоон үзүүлэлт, сүнслэг байдлын өсөлт аль алинд нь чухал ач холбогдолтой хүч байх болно.”¹¹

Есүс Христийн сайн мэдээ үнэн гэдгийг би гэрчилж байна. Их Эзэн Өөрийн охидыг, Сионы гэр бүлүүдийг бэхжүүлж, дэлхий дээр Түүний хаант улсыг байгуулахад хийх ёстой зүйлсээ хийнэ гэдэгт бид итгэлтэй байдаг. Тэд хувийн илчлэлт эрэлхийлж, илчлэлт хүлээн авахад өөрсдийгөө тэнцэхүйц зохистой байлгах аваас Их Эзэн энэхүү эцсийн өдрүүдэд шивэгчингүүд дээрээ ч Өөрийн Сүнсийг цутгах болно. Есүс Христийн нэрээр, амен.

ЭШЛЭЛ

1. Иаков 2:17, Мозая 4:26, Сургаал ба Гэрээ 38:35, 44:6-г үз.

2. Сургаал ба Гэрээ 20:77-г үз.

3. 2 Нифай 32:3-ыг үз.

4. 3 Нифай 19:24-33-ыг үз.

5. Сургаал ба Гэрээ 11:12.

6. Сургаал ба Гэрээ 11:13-14-ийг үз.

7. 1 Коринт 13:8.

8. 1869 оны 10 дугаар сарын 27-нд Элайза Р.Снөү (Ютагийн) Альпайн гадасны Лихай тойргийн Нийгмийн Халамжийн Бүлэгт хандаж хэлсэн үг, Relief Society Minute Book 1868-79, Church History Library, Salt Lake City, 26-27.

9. “Миний сайн мэдээг номло” (2004), 10-11-ийг үз.

10. Иосел 2:28-29-ийг үз.

11. Спенсер В.Кимбалл, “The Role of Righteous Women,” *Ensign*, 1979 оны 11-р сар, 103-4.